



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 13

Хажуу шинэ-Ус

Төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Сангийн хөрөнгөөр төсөл хүлээн авах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 03 -ны өдрөөс эхлэн 2023 оны 08 дугаар сарын 03-ний хооронд зохион байгуулсугай.

2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 08 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулахдаа журмын 2 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хороо (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ПҮРЭВСЭНГЭ

